

Иргэний нисэхийн ерөнхий газрын ажилтнуудын эрүүл мэндийн урьдчилсан үзлэгийн ажлын даалгавар

Эрүүл мэндийн үзлэгийг хийхдээ дараах үзлэг, шинжилгээний шаардлагыг хангаж ажиллана. Үүнд:

1. Магадлан итгэмжлэгдсэн эмнэлэг байна.
2. Нарийн мэргэжлийн ахлах, тэргүүлэх, зөвлөх зэргийн эмч мэргэжилтэнүүдтэй байх.
3. Урьдчилан сэргийлэх үзлэг хийх багаж тоног төхөөрөмжөөр хангагдсан байх.
4. Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа зохион байгуулж байсан туршлагатай байх.
5. Ажилтаны овог нэр, нас лабораторийн шинжилгээний хариуг үнэн зөв гаргаж, гарсан гомдол саналыг шийдвэрлэх боломжтой байх.
6. Нарийн мэргэжлийн эмч нар нь тухайн мэргэжлээрээ 5-с дээш жил ажилласан ажлын туршлагатай байх.
7. Эрүүл мэндийн үзлэгийг хуваарийн дагуу хугацаанд нь чанартай сайн үзэж ажилтан тус бүрээр ерөнхий эмчийн эрүүл мэндийн дүгнэлт гаргуулах.
8. Хэвтэн эмчлүүлэх шаардлагатай байгаа ажилтныг хэвтэн эмчлүүлэх боломжоор хангах, зардлыг ажилтан өөрөө хариуцна.
9. Үзлэг хийх өрөө кабинетийг дугаарлах, ажилтан үзүүлэх маршрут гаргах, үзлэгийн тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагаа бэлэн байдлыг хангаж ажиллах бүрэн боломжтой байх.

1. Нарийн мэргэжлийн эмч:

№	Мэргэжил	Ажилласан жил	Ажиллах эмчийн тоо
1	Зүрх судас	5-аас дээш жил	2
2	Элэг цөс, ходоод гэдэс	5-аас дээш жил	2
3	Бөөр	5-аас дээш жил	2
4	Уушиг	5-аас дээш жил	2
5	Дотоод шүүрэл	5-аас дээш жил	2
6	Мэс засал	5-аас дээш жил	2
7	Мэдрэл	5-аас дээш жил	2
8	Арьс, Харшил	5-аас дээш жил	2
9	Нүд	5-аас дээш жил	1
10	Чих хамар хоолой	5-аас дээш жил	2
11	Эмэгтэйчүүд	5-аас дээш жил	2
12	Ерөнхий эмч	10-аас доошгүй жил	2

2. Биеийн жингийн индекс-бодисын солилцооны үндсэн үзүүлэлтүүдийг тодорхой гаргаж өгөх.

3. Лабораторийн шинжилгээ:

3.1 Шээсний ерөнхий шинжилгээ

3.2 Цусны ерөнхий шинжилгээ

3.3 Эмэгтэйчүүд

- Мазок
- Эсийн шинжилгээ-/зайлшгүй шаардлагатай тохиолдолд/

4.Биохимийн шинжилгээ:

№	Биохимийн шинжилгээ		Хамрагдах ажилтаны тоо
1	Билирубин	Элэгний үйл ажиллагаа	792
2	Альбумин		792
3	ГОТ /АСАТ/		792
4	ГПТ/АЛАТ/		792
5	Шүлтлэг фосфотаз	Цөсний үйл ажиллагаа	792
6	Амилаза	Нойр булчирхайн үйл ажиллагаа	792
7	Сахар		792
8	Холестрин	Зүрх, судасны үйл ажиллагаа	792
9	Триглицерид		792
10	LDL, HDL		792
11	Креатинин	Бөөрний үйл ажиллагаа	792
12	Мочевин		792
13	Үлдэгдэл азот		792
14	Витамин Д		792

5. Иммунологийн шинжилгээ:

№	Иммунологийн шинжилгээ		Хамрагдах ажилтаны тоо
1	ASLO	Үе мөчний үрэвсэл	792
2	CRP		792
3	RF		792
4	H-pylori	Хелико бактери	792
5	В вирус маркер илрүүлэг, зайлшгүй тохиолдолд чанарын шинжилгээг ажилтан өөрийн зардлаар хийлгэх.	Элэгний вирус	792
6	С вирус маркер илрүүлэг, зайлшгүй тохиолдолд чанарын шинжилгээг ажилтан өөрийн зардлаар хийлгэх.		792

6. Багажийн шинжилгээ:

№	Багажийн шинжилгээ	Ашиглагдах аппарат	Хамрагдах ажилтаны тоо
1	Зүрхний цахилгаан бичлэг	1	792
2	Цээж гэрэлд харах	1	792
3	Хэвлийн эхо, эмэгтэйчүүдийн эхо, түрүү булчирхай	1	792
4	зүрхний эхо /зайлшгүй шаардлагатай тохиолдолд/	1	/зайлшгүй шаардлагатай тохиолдолд/
5	Сонсгол шалгах / зайлшгүй шаардлагатай тохиолдолд/	1	/зайлшгүй шаардлагатай тохиолдолд/
6	Хараа шалгах, нүдний уг дурандах, харааны талбай тодорхойлох, харааны өнгө шалгах	1	792
7	Ясны сийрэгжилт	1	792

7. Нэмэлтээр: Нарийн мэргэжлийн эмчийн санал болгосноор- Хавдрын маркер, Эрдэсүүд /Кали, Кальци, Магни гэх мэт/, судасны бичлэг/Допплерограмма/, тархины цахилгаан бичлэг, СТ хийлгэх зардлыг ажилтан өөрөө хариуцна.

8. Эрүүл мэндийн нэгдсэн дүгнэлт: Ерөнхий эмчийн үзлэг хийж дүгнэлт гаргах.

Жич: Нэмэлт санал болгосон ажлууд төлбөртэй эсэхийг тендерийн материалд тодорхой зааж ирүүлэх нь тендерийг үнэлэхэд давуу болно.